

2016-04-14

Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал (2016 оны 3-р сарын байдлаар)



I. Нийгмийн байдал

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэдийн тоо 2016 оны 3 дугаар сард 286 байгаагийн 160 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 84 буюу 41.5 хувиар, өмнөх сарынхаас 42 ажил хайгч буюу 17.2 хувиар тус тус өссөн байна. Эхний 3 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 66 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 27 буюу 69.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Улсын бүртгэл, статистикийн газрын Бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 3 дугаар сарын байдлаар 102 эх амаржиж, 103 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх болон мэндэлсэн хүүхэд 1 буюу 1.0 хувиар өссөн байна.



II. Нийгмийн даатгал, халамж

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 3 дугаар сард 1556.5 сая төгрөг, зарлага 2152.8 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 81.1 сая төгрөг буюу 4.9 хувиар буурч, зарлага 113.9 сая төгрөг буюу 5.6 хувиар өслөө. Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 3 сард 3140 хүнд 416.7 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 422 хүн буюу 15.5 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 34.4 сая төгрөг буюу 9.0 хувиар тус тус өссөн байна.



III. Эрүүл мэнд

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 3 сарын байдлаар 105 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 103 үүнээс 54 нь хүү, 49 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 7 буюу 7.1 хувиар, төрсөн хүүхэд 6 буюу 6.2 хувиар тус тус өссөн байна. Он гарсаар 33909 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 7691 буюу 29.3 хувиар, 1324 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 233 буюу 21.3 хувиар тус тус өссөн байна.



IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 3 сард 47 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 хэрэг буюу 7.8 хувиар буурсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо буурахад хүний амь, бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 4 буюу 16.0 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна. Илрээгүй гэмт хэргийн тоо 10, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 66.0 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс илрээгүй гэмт хэрэг 1 буюу 9.1 хувиар буурч, илрүүлэлтийн хувь 7.9 пунктээр өссөн байна.



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм. Хэрэглээний үнийн индекс 2016 оны 3 сард 105.2 болж өмнөх оны мөн үеийнхээс 5.2 хувиар өсч, жилийн эцсээс 0.1 хувиар буурсан, өмнөх сараас 0.2 хувь өссөн үзүүлэлттэй байна.



VI. Орон нутгийн төсөв

2016 оны эхний 3 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 3690.2 сая төгрөг, гүйцэтгэлээр 3393.2 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 327.1 сая төгрөг буюу 10.7 хувиар өсчээ. Аймгийн төсвийн нийт зарлага 3916.3 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 3039.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 877.0 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 308.4 сая төгрөг буюу 11.3 хувиар өссөн байна.



VII. Мал аж ахуй

Аймгийн хэмжээнд 2016 оны эхний 3 дугаар сард төллөсөн хээлтэгч 16014 байна. Эм хонь 7843, эм ямаа 7294, үнээ 730, гүү 122, ингэ 25 төллөжээ. Гарсан төлийн 96.5 хувь буюу 15624 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 21200 толгойгоор бага байна. 2016 оны эхний 3 сард том малын зүй бус хорогдол 8111 болж, өмнөх оны мөн үеийнхээс 8015 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 2 мал байна.



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2016 оны эхний 3 сард 12966.4 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4144.5 сая төгрөг буюу 47.0 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 2406.1 сая төг буюу 23.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 12729.6 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 2406.0 сая төгрөг буюу 23.3 хувиар өслөө. Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 11955.6 сая төг буюу 92.2 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.

Материал бэлтгэсэн: Мэргэжилтэн.....С.Эрдэнэзаяа